СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа
Соёлын өвийн үндэсний төв

# ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

## “RCH-Registration of Cultural Heritage” программд бүртгэсэн байдлаар

Д.Нарантуяа. Соёлын өвийн бүртгэл,
судалгааны газрын ахлах мэргэжилтэн

Улаанбаатар. 2018 оны 04 сарын 06

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

- “RCH” бүртгэлийн бүрдүүлэлт
- Бүртгэл дэх бичвэрийн хэл найруулгыг хянах, үг, үсгийн алдааг засах

# МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ


Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 541-р тушаалын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар: ______________

| | |
|---|---|
| Өмчлөгч: | РД: |
| Эзэмшигч: | РД: |

Дурсгалт зүйлийн орших байгаа хаяг:

Ашиглалтын байдал:

| | |
|---|---|
| Дурсгалт зүйлийн нэр: | Хувийн дугаар: |

Улс, орон нутаг, шинжлэх ухааны нэр:

☐ Эх бүтээл ☐ Хуулбар

| | |
|---|---|
| Зэрэглэл: | Шийдвэр: |

Төрөл зүйл:

Он цаг:

Бүтээлч, сургууль хийц:

Материал, арга ажиллагаа:

| Хэмжээ | Өндөр | Өргөн (урт) | Зузаан | Голч | Жин |
|---|---|---|---|---|---|
| Ерөнхий | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Бусад хэмжээс:

| | |
|---|---|
| Иж бүрдэл: | Тоо ширхэг |

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР нь:**

**6701ХӨМ00001**

**- засаг захиргааны нэгжийн код,**

**- эзэмшигч байгууллагын нэрийн товчилсон үсэг,**

**- дурсгалын дэс дугаар.**










**БСШУ-ны сайдын 2010 оны 541-р тушаалаар батлагдсан “МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ”**-ийн маягт

**“МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ”-ИЙН цахим хэлбэр “RCH буюу REGISTRATION OF CULTURAL HERITAGE”** програм хангамж

# МОНГОЛ УЛСЫН ТҮҮХ, СОЁЛЫН ХӨДЛӨХ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН БҮРТГЭЛ




**RCH** програм хангамжийг нээхэд зүүн гар талд тухайн хүснэгтэд ямар мэдээлэл бичих тухай заавар гардаг.

# Эрэлт, хайлт их хийгддэг талбаруудад бичвэрийн тэмдэгтүүдийг жигдлэх талаар, Жишээ нь: “Хувийн дугаар” талбар



Бүлэглэлт хийхдээ бүлэглэх гэж буй багана

| | Үзмэрийн нэр | Бус | Зэр | Бүртгэлийн ангил | Хувийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 00012 | Сийлбэртэй том м... | | | Ерөнхий бүртгэл | ГА. Ү 82-55 |
| 00024 | Үзэгний сав | | | Ерөнхий бүртгэл | ГА. Ү 90-25 |
| 00026 | тосгуур цорго | | | Ерөнхий бүртгэл | ГА.Ү.84,25, |
| 00104 | Аймгийн 60 жили... | | | Ерөнхий бүртгэл | ГА. Ү 01-6-1 |
| 00107 | Ширээний цаг | | | Ерөнхий бүртгэл | ГА.Ү90,27 |




“Хувийн дугаар”-ыг бичихэд анхаарах:

- Бүртгэлд цэг, дундуур зураас, таслал зэрэг тэмдэгтүүдийг хольж бичих, тэмдэгт хоорондын зай авалтыг янз бүр бичсэнээр RCH програмд эрэлт, хайлт дутуу хийгддэгийг анхаарна уу. Иймд хувийн дугаарыг бичихдээ цэг, дундуур зураас, таслал болон тэмдэгт хоорондын зай авалт зэргийг жигдлэснээр эрэлт хайлтын дүнд мэдээлэл бүрэн гарна.

  “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын 2.2.11-д “Музейн нэрийн товчилсон үсгийн дараа цэгээр тусгаарлан бүлэг тоонууд үүсгэж, хувийн дугаарыг дараах байдлаар өгнө.” гэж заасан байдаг.

- “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”-ын дагуу 2012 оны улсын тооллогоор музейнүүд хувийн дугаар өөрчлөлт хийсэн байна. RCH-д хийсэн хувийн дугаарын өөрчлөлтийн талаарх мэдээллээ оруулаагүй, хуучин хувийн дугаараар байгаа засах.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ

# Мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв оруулах: Жишээ нь: “Зэрэглэл” талбар




**Тухайн үзмэр, эд өлгийн зүйл Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.8-д заасны дагуу Засгийн газрын шийдвэрээр “Түүх, соёлын хосгүй үнэт” зэрэглэлд батлагдсан тухай Засгийн газрын тогтоолын огноо, дугаарыг сонгоно.**




**Засгийн газрын тогтоолд бичигдсэн дугаарыг бичнэ.** ***/2018 оны 4-р сарын байдлаар түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт 1-ээс 777 хүртэл дугаарлагдсан байна/.***

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

“Зэрэглэл” талбарыг сонгоход анхаарах:



| Зэрэглэл | Бүртгэлийн ангил | Хувийн дугаар | Зү | | Иж бү | Он цаг | Бүртгэсэн огноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-06-269 | 1 | . | 1 | | 4/20/2015 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-06-250 | 3 | . | 1 | | 4/14/2015 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-06-267 | 1 | . | 1 | | 4/17/2015 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-06-282 | 1 | . | 1 | | 4/24/2015 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-06-246-01 | 3 | . | 1 | | 4/10/2015 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-06-268 | 1 | . | 1 | | 4/20/2015 |
| Үнэт | Ерөнхий бүртгэл | Y-60-02 | 2 | . | 1 | | 12/15/2009 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-59-23 | 2 | . | 1 | | 12/15/2009 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-59-22 | 2 | . | 1 | | 12/14/2009 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-59-27 | 2 | . | 1 | | 12/15/2009 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | Y-59-24 | 2 | . | 1 | | 12/15/2009 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | 08-304 | 2 | . | 1 | | 1/19/2017 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | 08-285 | 2 | . | 1 | | 1/19/2017 |
| Ердийн | Ерөнхий бүртгэл | 08-309 | 3 | . | 1 | | 1/19/2017 |




**2014 онд шинэчилсэн найруулгаар батлагдсан Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “Ердийн” зэрэглэлийг хассан.**

**Жишээ: - СӨХТХ-ийг 2014 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж мөрдсөн ба уг цаг хугацаанаас хойш хийгдсэн бүртгэл хэрнээ “Ердийн” зэрэглэлийг сонгож бүртгэсэн байна.**

**- Мөн хуулийн 14.1.6-д Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Үнэт” зэрэглэлд батлахаар хуульчилсан. Өнөөг хүртэл албан ёсоор түүх, соёлын үнэт зэрэглэлд баталсан тухай шийдвэр гараагүй байгаа тул “Үнэт” гэсэн зэрэглэлийг сонгохгүй.**

**ИЙМ АЛДААНУУДАА ЗАСАХ !**

**Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл <u>үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна</u>.**

*/Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.8 дахь заалт/*

## Үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл буюу “Register”

| Эд өлгийн зүйлийн хувийн дугаар | Хуучин хувийн дугаар | Эд өлгийн зүйлийн нэр, төрөл зүйл | Хэмжээ, үнэт металлын нэр, сорьц, жин, үнэт чулууны тоо ширхэг, жин каратаар | цаг А. Бүтээсэн Б. Хэрэглэж байсан В. Цуглуулсан |
|---|---|---|---|---|
| <u>СҮМ1959.3.1</u> | 150, <u>74.30.1</u> | <u>Дарьганга толгойн гоёл, 3.4. Дээл хувцас, гоёл чимэглэл</u> | <u>Урт: 46см, Өргөн: 7.5см, Өндөр: 9.5см, Жин: 820гр, Үнэт чулууны тоо ширхэг: 183</u> | А. <u>Ш.Дондов</u> А. <u>XIX зууны дунд үе</u> |
| <u>СҮМ1959.3.2</u> | 147,1 46, <u>74.33</u> | <u>Дарьганга хавчаар,</u> 3. Угсаатны зүй | Урт: 151см, Өргөн: 7.5см, Жин: 1515гр, Үнэт металлын нэр: Мөнгө, Үнэт чулууны тоо ширхэг: 68 | А. <u>Ш.Дондов</u> А. <u>XIX зууны сүүл үе</u> |

<u>Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлд батлах тухай **Засгийн газрын 2013 оны 227 дугаар тогтоол дахь бичвэр**</u>:

772.
Дурсгалын нэр: ДАРЬГАНГА ЭХНЭРИЙН ТОЛГОЙН ГОЁЛ ХАВЧААР
**Бүтээлч:** <u>**Ш.Дондов**</u>
**Холбогдох он цаг:** <u>**1906-1907 он**</u>
Хадгалагдаж буй газар: Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей
Дурсгалын шинж байдал: Толгойн гоёл: мөнгө, шүр, даавуу, <u>өндөр 6см, жин 820гр</u>. Хавчаар: мөнгө, шүр, ундрам, даавуу, хялгас, <u>өргөн 7,5см, урт 151см,</u> жин 1510гр.
**Хувийн дугаар:** <u>СҮМ1959.3.1</u> (Толгойн гоёл) <u>СҮМ1959.3.2</u> (Толгойн хавчаар)

## Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл буюу RCH







Бүтээсэн он цаг: **XIX зуун буюу 1800-1899 он**




Ш.Дондов нь **1912-1984 он** буюу **XX зуунд** амьдарч байсан.




**Жишээ: Register болон RCH-ийн бүртгэлд**
**ДУРСГАЛЫН НЭР,**
**БҮТЭЭСЭН ОН ЦАГ,**
**БҮТЭЭЛЧ,**
**ХЭМЖЭЭ,**
**ХУВИЙН ДУГААР,**
**ЗЭРЭГЛЭЛ**
**зэрэг мэдээллүүд нь зөрүүтэй байна.**

# "ТӨРӨЛ ЗҮЙЛ" ТАЛБАРЫН ТУХАЙД




- "Төрөл зүйл"-ийн сонголт бий болсноор музейн сан хөмрөг цуглуулгийн төрөл зүйл, бүтцийн талаарх тоон үзүүлэлтийг цахимаар гаргах боломжтой болсон.

- Төрөл зүйлийг сонгох тухай зөвлөмжийг веб сайт, гарын авлага байдлаар музейнүүдэд тараасан.

- "Төрөл зүйл"-ийг зөв сонгосноор сан хөмрөг цуглуулгынхаа төрөл зүйлийн бүтэц, тоон үзүүлэлтийг гаргах, улмаар үзмэр цуглуулгын бодлого төлөвлөлтөд ашиглах боломжтой.




**Түүхийн холбогдолтой – Бэлгэдэл, таних тэмдгийн холбогдолтой эд өлгө**




**Угсаатны зүйн –Гэр зуурын үйлдвэр, гар урлал**

# “ОН ЦАГ” ТАЛБАРЫН ТУХАЙД







- “Он цаг” сонголтын талбарт Их Монгол улсын үеэс хойшхи он цагийн сонголтоос “түүхэн үелчлэл”-ийн нэрийг хасаж, бүтээсэн он цагийн “зуун”-ыг сонгох эсвэл тодорхой “он”-ыг бичиж оруулдаг байх зэрэг өөрчлөлт хийхээр бэлдэж байна.

# Бичвэрийн хэл найруулга зүй, үг үсгийн алдааг засах, сайжруулах

- Бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн бүртгэлүүдээс үзэхэд зарим бүртгэлд мэдээллийн агуулгыг давхардуулан бүртгэх явдал байна. Тухайлбал: “Анх цуглуулсан, нээж илрүүлсэн”, “Хамгаалалтад авсан шийдвэр” эсвэл “Товч түүх” талбаруудад мэдээллийг давхардуулан бичиж байна.
- “Товч түүх”, “Тодорхойлолт” зэрэг талбарууд бол бүртгэлийн хамгийн чухал хэсэг. “Тодорхойлолт” талбарт үзмэр, эд өлгийн зүйлийн гадна төрх байдал болон түүнд агуулагдаж байгаа мэдээллийг үгээр илэрхийлэн бичихэд судалгааны үр дүн чухал ба музейн ажилтнаас мэргэжил мэдлэг, чадвар шаарддаг.
  - **Үзмэр, эд өлгийн зүйлийн гадна хэлбэр төрх, физик шинж байдлыг оновчтой үг, хэллэгээр тодорхойлон бичих,**
  - **Үзмэрийн хэлбэр төрх, шинж байдлыг дэс дараалалтайгаар, эмх цэгцтэй дүрслэн бичих нь чухал,**
  - **Уншихад ойлгомжтой, найруулга сайтай байх,**
  - **Хоёрдмол утга санаа илэрхийлсэн үг, хэллэг хэрэглэхгүй байх,**
  - **Үг, үсгийн алдаагүй байх,**
  - **Өгүүлбэрийг, Оноосон нэр (байгууллага, газар нутгийн г.м)-ийг том үсгээр эхлэн бичих, таслал, цэг тэмдэг зөв тавих, үг хоорондын зай авалт, үг товчлохгүй байх зэрэг зөв бичгийн дүрмийг баримтлах.**

# Бичвэрийн хэл найруулга зүй, үг үсгийн алдааг засах, сайжруулах

Иж бүрдэл

22 ширхэг

?

Тодорхойлолт

Нум,сум, пүрэв,арилд,дэгүг,цалам, очиртой хонх,очиртой жижиг сух зэрэг шашны зан үйлд муу муухай зүйлийг айлган сүрдүүлж зайлуулдаг лянганы гэж нэрлэгддэг шашны зан үйлийн багаж хэрэгсэл. Үзмэр үзүүллэгт байгаа 12 ш багаж нь бүгд очир толгойтой хатуу металлаар цутгаж хийсэн. Багажны очир толгойнууд бүгд гууль шармал. Бүгд багаж жижиг хэмжээтэй харьцангуй урт иштэй эртний Энэтхэгийн цэргийн байлдааны зэвсгийг дуурайлгаж хийсэн гэлтэй.

Тодорхойлолт

Луун хээтэй /дугуй /шар торгон материалтай. Дотор талыг нь цагаан саарал энгийн даавуугаар хийсэн. мөн ханцуй, захыг нь мөн цагаан даавуугаар хийсэн. Энгэртээ 2 ширхэг даавуун зангидах зориулалттай 2 ширхэг товчтой.

Тодорхойлолт

Улаан энгийн хүрээн дотор шороон будгаар цаасан дээр зурсан. үүлэн хээтэй хөх дэвсгэр дээр, аравч нь галан сэнтйи д заларсан. Хөх энгийн биетйэ, хээтэй хөр энгийн өмсгөлтэй, суугаа байдалтйа, 3 нүдтэй, 4 соёотой, догшин дүртэй бурхныг дүрсэлсэн.Баруун гараа өвдөг дээрээ авсан чандмана эрдэнийг барьсан. Зүүн гараа хэвлий тус газраа авч рашааны бумба барьсан.

# Үзмэрийн нэмэлт, баяжилт мэдээллийг баримтжуулан бүртгэх:

- Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл буюу RCH бүртгэлд "Судлагдсан байдал", "Шилжилт хөдөлгөөн", "Сэргээн засварласан", "Хуулбар хийсэн" зэрэг талбаруудад үзмэрийг хөдөлгөөнд оруулж байгаа үйлдэл, үйл явцыг байнга нэмж, бүртгэн баримтжуулалт хийгдэж байдаг.
  - Бүртгэлд гарч буй нэмэлт, баяжилтийн талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь бүртгэдэг ажлыг хэвшүүлэх:
  - RCH-ийн талбаруудад нэмэлт баяжилт мэдээллээ бүрэн гүйцэд оруулж байх. Мэдээллээ оруулахдаа эрх бүхий албан тушаалтны гаргасан тушаал шийдвэрийн огноо, дугаарыг бүрэн гүйцэд бичдэг байх.

    - Тухайлбал: "Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар" /2012 он/-ын дагуу хийгдсэн хувийн дугаарын өөрчлөлтийн талаарх,

    - 2014 онд шинэчлэгдсэн Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт орсон Мерчандайз, хэв загвараар бүтээгдэхүүн болгон ашиглаж байгаа үзмэрүүдийнхээ талаарх мэдээлэл зэрэг.

    - Үзмэр сэргээн засварлагдаж, хуулбар хийгдэж дууссаны дараа цаг тухай бүрд нь холбогдох мэдээллүүдийг бүртгэж баримтжуулж байх.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Үзмэрийн нэмэлт, баяжилт мэдээллийг баримтжуулан бүртгэх:

## Жишээ нь: “Сэргээн засварласан” талбар




Сэргээн засварлалт хийх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дугаар огноо, хэдэн онд, хаана ямар байгууллага, үзмэрийн аль хэсэгт яаж сэргээн засварлалт хийгдсэн тухай мэдээлэл нь дутуу байна.




- “Сэргээн засварлалтын баримтын дугаар” хэсэгт сэргээн засвар хийсэн газраас өгсөн баримтын дугаарыг бичнэ. Соёлын өвийн үндэсний төвийн сэргээн засварлах газраас сэргээн засварлалт хийгээд музейд үзмэртэй цуг “Сэргээн засварласан тухай товч маягт”-ыг дагалдуулж өгдөг. СӨҮТөвөөс өгсөн дагалдах хуудсыг бүртгэлд хэрхэн тусгаж байна ?

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

# Үзмэрийн нэмэлт, баяжилт мэдээллийг баримтжуулан бүртгэх:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.2; 32.2.3-т заасны дагуу 2015 оноос эхлэн БМСангуудаас жил бүрийн эхний 1 дүгээр сард өмнөх оны сан хөмрөгийн баяжилт, бүртгэлтэй холбоотой тайланг тоон үзүүлэлтээр авч байгаа. Үүнд:

- Сан хөмрөгт авсан үзмэр, эд өлгийн зүйлийн төрөл зүйлийн үзүүлэлт, арга зам;
- Гадаад, дотоод үзэсгэлэн, Судалгаа шинжилгээнд хамрагдсан, Сэргээн засварлагдсан гэсэн тоон үзүүлэлтээр.

2018 оноос эхлэн тайланг:

- Үзмэрийн ”Судлагдсан байдал”, “Гадаад, дотоод үзэсгэлэн буюу Шилжилт хөдөлгөөн”, “Сэргээн засварласан” мэдээллүүдээ RCH-ийн бүртгэлд оруулсан эсэх байдлаар тодорхой, нарийвчлан авч байхаар зохицуулалт хийж байна.
- Тайлагнах үзүүлэлтүүдийг тусгайлан цахим хэлбэрээр авч, дүн мэдээг нэгдсэн байдлаар гаргадаг болно.

| **Object ID /Эд зүйлийн тодорхойлолт/** | **Монгол Улсын Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл “RCH” /35 асуулгатай/** | **Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл “Register” /21-25 асуулгатай/** |
| --- | --- | --- |
| **Нэр** | Дурсгалын нэр | Дурсгалын нэр |
| - | Хувийн дугаар | Хувийн дугаар |
| - | Ашиглалтын байдал | Сан хөмрөгийн байршил |
| Эд зүйлийн төрөл | Төрөл зүйл | Төрөл зүйл |
| **Хугацаа буюу эрин үе** | Он цаг | Холбогдох нэр, газар, он<br>А.Бүтээсэн |
| **Зохиогч** | Бүтээлч | |
| **Материал арга техник** | Материал, арга ажиллагаа | Материал арга техник |
| Хэмжилт | Хэмжээ | Хэмжээ |
| - | Анх цуглуулсан, нээж илрүүлсэн | Холбогдох нэр, газар, он<br>В. Цуглуулсан |
| - | Хамгаалалтанд авсан тогтоол шийдвэр | Музейд авсан шийдвэрийн дугаар, он цаг |
| **Товч тайлбар бичих** | Тодорхойлолт<br>Дүрслэх бичих<br>Физик шинж чанар<br>Тэмдэг бичээс | Тодорхойлолт<br>А.Дүрслэн бичих<br>Б.Тэмдэг бичээс<br>В.Ялгагдах онцлог |
| Сэдэв | | |
| **Бичээс тэмдэг** | | |
| **Ялгах онцлог шинж** | Гэмтэл | Хадгалалтын байдал: Гэмтэл |
| | Сэргээн засварлагдсан байдал | |
| **Гэрэл зураг** | Гэрэл зураг | Гэрэл зураг |

- ✓ Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу мэдээллийг үйлдэж, хадгалалтын байдлын тайлан, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулна.

*/Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52.6 дахь заалт/*

- ✓ Хууль бусаар гадаадад гарсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл энэ хуулийн 52.1, 52.3-т заасны дагуу улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны захиргааны байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулна.

*/Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52.7 дахь заалт/*

**Аливаа гарч болох эрдэлээс сэргийлж үзмэр, эд өлгийн зүйлсээ “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийн цахим RCH-д бүртгэх ажлыг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай байна.**

## Тухайн дурсгалын холбогдох Негатив, Слайд, CD, DVD, Дүрс бичлэгийн хуурцаг хальсны тэмдэглэгээ

- Негатив, слайд, CD, DVD, хуурцаг зэргийг музейн үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг.

- RCH бүртгэлүүдээс үзэхэд энэ талбарт тэмдэглэгээ огт хийгдэхгүй байна.

- Бүртгэл, мэдээллийн санч мэдээллийнхээ санд хадгалагдаж, ашиглагдаж байгаа негатив слайд, дурсгалын холбогдолтой бүртгэл, гэрэл зураг CD, DVD, хуурцагыг архивын хууль, дүрэм, журмын дагуу бүртгэн товъёгжуулан архивлан хадгалах ажлыг хийнэ.

- УНБМСангаас зохион байгуулсан өмнөх сургалтуудад БМСангийн бүртгэл, хэрэглэгдэхүүнийг архивлан хадгалах, товъёог бүртгэлжүүлэх тухай заавар, зөвлөмжүүдийг өгч байсан.

Хэрэв эзэмшигч (өмчлөгч) -д тухайн дурсгалтай холбоотой негатив, слайд, сд двд, хуурцаг байгаа бол

| Негатив № | Слайд № | CD / DVD № | Хуурцаг № |
|---|---|---|---|
| 0 | 0 | 0 | 0 |

Соёлын өвийн төв-д хадгалагдаж байгаа

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Музейн удирдлагын зүгээс:

Соёлын өвийг бүртгэн баримтжуулах үйл ажиллагаа нь цаг хугацаа, хүн хүч, техинк хэрэгсэл, хөрөнгө санхүү шаардаж байгаа хэдий ч зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай.

- ✓ Бүртгэл дэх бичвэрийн хэл найруулгыг засаж сайжруулах;
- ✓ Үг, үсгийн алдааг маш их байгааг анхаарч засах талаар арга хэмжээ авах:
- ✓ Үзмэртэй холбоотой нэмэлт баяжуулалт мэдээллүүдийг цаг тухай бүрд нь бүртгэлд нэмж оруулах, бүртгэх ажлыг хэвшүүлэх;
- ✓ RCH бүртгэлийн програмд бүртгэгдээгүй үзмэр, эд өлгийн зүйлээ бүртгэж оруулах ажлаа тогтмолжуулах;
- ✓ Үзмэр, эд өлгийн зүйлсийг бүртгэхэд тэдгээрийн түүх, соёл, шинжлэх ухааны тухай мэдээ, мэдээллийг эрэн сурвалжлах, судлах, олж илрүүлэхэд ажилтнуудын мэдлэг чадавхийг сайжруулах;
- ✓ Зөвхөн RCH бүртгэл хөтлөлтөөр зогсохгүй, СӨХТХуулийн дагуу БМСан бүрдүүлэлтийг хангаж ажиллах.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Соёлын өвийн үндэсний төвийн зүгээс:

- ✓ Соёлын өвийг бүртгэн баримтжуулах мэргэжил арга зүйгээр хангах байнгын үйл ажиллагаатай Сургалтын төв бий болгохоор зорьж байна.
- ✓ Үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэл, бүрдүүлэлтийн чанар байдлыг сайжруулахад холбогдох хууль эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулах, бүртгэлийн маягтыг сайжруулахаар баримт бичгийн төслийг боловсруулаад бэлэн болгосон байна.
- ✓ “Register” болон “RCH” програмуудыг нэгтгэх, холбох ажиллагааг ойрын үед хийнэ.
- ✓ Музейн бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Анхаарлаа хандуулсанд баярлалаа

www.monheritage.mn